*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2020 оны 100 тоот тушаалын*
*7 дугаар хавсралт*

# ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАХИН ЗАГВАРЧЛАЛЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл -ийн хувь |
| **ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨРИЙН 2.5.4. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН 4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | | |
| **ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ:** "Алсын хараа-2050"-ын 5.3.1, Алсын хараа 2050-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.1, 5.3.2, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.1, ЗГҮАХ-ийн 4.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн.... | | | | | | | | |
| **НЭГ.Зорилт 2.5.4.1.Төрийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, бизнес процессын дахин инженерчлэл хийх** | | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 **Яамны төлөвлөгөөний 37.** Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх аргачлал боловсруулах, эрх зүйн орчныг бий болгоно. | - | Аргачлалын тоо | 0 | - | 1 | тайлант хугацаа болоогүй. | - |
| 2. | Арга хэмжээ 1.2 **Яамны төлөвлөгөөний 38.** Төрийн байгууллагын үйлчилгээнд процессын дахин инженерчлэл, шинжилгээ хийнэ. | - | Байгууллагын тоо-2 | 0 | - | 2 | Тус яамнаас Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Ухаалаг засаг 2 төсөл”-ийн 2026 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 2.1.11.2-д “Төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэл хийх” төслийн ажлын | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | даалгаврыг боловсруулах чиглэлийг хүргүүлсэн.<br><br>Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын А/102 дугаар тушаалаар Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ээр дамжуулан үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дахин загварчлах, үе шатыг бууруулах талаар санал, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгээс гарсан үр дүнг Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. | |
| 3. | Арга хэмжээ 1.3<br>**Яамны төлөвлөгөөний 39.**<br>Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ийг тархсан бүтцэд шилжүүлнэ. | - | Тархмал бүтцэд шилжсэн мэдээлэл хариуцагч байгууллагын тоо | 0 | 3 | - | - “Ухаалаг засаг 2 төсөл” -ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 2.2.2.2-т заасан “Бие даасан техникийн зөвлөх/ХУР систем”-ийн зөвлөх сонгон шалгаруулж, 2025 оны 04 сарын 04-ний өдрийн №2222 дугаартай гэрээ байгуулагдсан.<br><br>- “Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-ийг тархсан бүтэц шилжүүлэх” зөвлөх үйлчилгээний ажлын явц болон гүйцэтгэгчийн тайланг хянан баталгаажуулах үүрэг бүхий ажлын хэсгийн тушаалын төсөл /бүрэлдэхүүн, удирдамж/-ийг мэдээллийн технологийн төсөл, хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтний хамт боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/188 дугаар тушаалаар батлуулсан.<br>- "Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-ийг тархсан бүтэц шилжүүлэх" арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх техникийн зөвлөх И-Монгол академи УТҮГ, Үндэсний дата төв УТҮГ дээр биечлэн ажиллаж, ажлын даалгаврыг боловсронгуй болгох, харьцуулсан судалгааны ажил тус тус хийгдэж байна. | |
| 4. | Арга хэмжээ 1.4<br>**Яамны төлөвлөгөөний 40.**<br>Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт боловсруулна. | - | Хүргүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн тоо | 0 | 6 | 12 | Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнөзөвлөмж, дүгнэлт авах хүсэлтийг isr.gov.mn системд 2025 онд<br>- Төрийн орон сууцны корпораци ХХК-ны Түрээсийн орон сууцны цахим систем,<br>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хоригдогсдын бүртгэл, хяналтын систем,<br>- Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн агуулахын бүртгэлийн систем,<br>- Ашигт малтмал, газрын тосны газрын тайлан бүртгэлийн mpetro.smartsolution.mn систем<br>- Үндэсний статистикийн хорооны Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн системд тус тус зөвлөмж дүгнэлт өгсөн байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Хууль зүйн туслалцааны төвөөс санал авахаар 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/70 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Хиймэл оюунд суурилсан хууль зүйн зөвлөгөө өгөх систем"-ийн ажлын даалгавартай танилцан холбогдох баримт бичгийг судалж, саналыг албан бичиг (2025.02.18, 03/367)-ээр хүргүүлсэн. | |
| 5. | Арга хэмжээ 1.5<br>Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас (gov.mn)-ыг ашиглах заавар, аргачлалыг боловсруулж, батлуулах | - | Батлагдсан баримт бичгийн тоо | 0 | 1 | - | Төрийн байгууллагын нэгдсэн вэб хуудсыг Нээлттэй мэдээллийн shilen.gov.mn-тэй уялдуулан хөгжүүлэхээр вэб хуудасны цэсний жагсаалт болон байгууллагын бүтцийг эцэслэн боловсруулж 2025 оны 4 дүгээр сарын 08-ны өдөр И-Монголиа академи-д хүргүүлсэн. Мөн 2025 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр Аствишн ХХК, И-Монголиа академийн холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж мэдээлэл солилцох шаардлагатай талбарын жагсаалтыг гаргахаар ажиллаж байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн e-mongolia 5.0 төслийн хөгжүүлэлт вэб 26%, мобайлын 24% явцтай хийгдэж байна. e-mongolia 5.0 төсөлд Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудсыг нэг загвар бүхий нэгдсэн удирдлагатай болгон хөгжүүлж, | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ "и-Монголиа"-тай холбох ажил багтсан болно. | |
| 6. | Арга хэмжээ 1.6<br>“Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | - | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | - | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/18 дугаар тушаалаар батлагдсан “Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ын шинэчлэн боловсруулж 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдөр mddic.gov.mn сайтаар олон нийтээс санал авахаар байршуулсан.<br>Зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий 2022 оны А/25 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгийн тушаалыг шинэчлэн ЦХИХХС-ын 2025 оны А/55 дугаар тушаалаар батлагдсан. | 100 |
| **ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ:** "Алсын хараа-2050"-ын 5.3.1, Алсын хараа 2050-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.1, 5.3.2, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.1, ЗГҮАХ-ийн 4.1.2, Цахим үндэстэн баримтлах чиглэлийн зорилт 2, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн ... | | | | | | | | |
| **ХОЁР.2.5.4.2.цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах** | | | | | | | | |
| 7. | Арга хэмжээ 2.1<br>Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулж, Засгийн | - | Хүргүүлсэн баримт бичгийн тоо | 1 | 1 | - | “Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-ийг тархсан бүтэц шилжүүлэх” зөвлөхийн бэлтгэсэн санал, зөвлөмжийг үндэслэн III-IV улиралд шаардлагатай өөрчлөлт оруулах төслийг боловсруулахаар төлөвлөсөн. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. | | | | | | | |
| 8. | Арга хэмжээ 2.2<br>**Яамны төлөвлөгөөний 47.**<br>“Дижитал-Аймаг, Дижитал-Хот” бодлогын зөвлөмжийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана. | 2,100.0 Урсгал зардал | Зөвлөмж хэрэгжүүлсэн аймаг, дүүргийн тоо | 2 | - | 8 | “Цахим аймаг – Дижитал хот” зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх ажлын хэсгийн тушаалыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2005 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлуулан. Ажлын хэсгийн хурлыг 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хийж ажлын хэсгийн ажиллах төлөвлөгөөг баталсан. Цахим аймаг – Дижитал хот” зөвлөмжийн төслийг боловсруулан засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээр бэлтгэсэн байна. 2025 онд “Цахим аймаг – Дижитал хот” зөвлөмжийг хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааны ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ны өдөр ТНБД-р батлуулсан. Ажил гүйцэтгэх нээлттэй тендерийг 2025.05.08-ны зарлаж 2025.05.29-ны өдөр нээсэн тендер үнэлэх үйл ажиллагаа явагдаж байна. | 70 |
| 9. | Арга хэмжээ 2.3<br>Иргэд Төрийн үйлчилгээний нэгдсэн систем ашиглан төрийн бодлого, шийдвэр гаргалтад цахим хэлбэрээр санал өгөх боломжийг бүрдүүлнэ. | - | Нэвтрүүлсэн системийн тоо | 0 | 1 | - | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем ашиглан төрийн бодлого, шийдвэр гаргалтад цахим хэлбэрээр санал өгөх боломжийг бүрдүүлэх зорилгоор Өргөдөл, гомдол, санал хүсэлт гаргах үйлчилгээг системээр дамжуулан иргэдэд үзүүлэх боломжийг бүрдүүлсэн.<br>Мөн Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төв болон бусад | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | холбогдох байгууллагуудтай уулзалт төлөвлөн ажиллаж байна. | |
| 10. | Арга хэмжээ 2.4<br>**Яамны төлөвлөгөөний 12.**<br>Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулна. | - | Цахим хэлбэрт шилжүүлсэн зөвшөөрлийн тоо | 0 | 1 | - | Төрөөс олгох тусгай зөвшөөрлийг цахимжуулах үйл ажиллагаа тодорхой хэмжээнд хэрэгжиж e-business.mn цахимжсан 44 үйлчилгээ тусгай зөвшөөрлийг цахимжуулсан, 134 тусгай зөвшөөрлийг e-business.mn-д линкээр холбон цахимжуулсан. Мөрөөс олгох энгийн зөвшөөрлийг цахимжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлж e-business.mn-д 23 зөвшөөрлийг цахимжуулан 58 зөвшөөрлийг линкээр холбон үйл ажиллагаа хялбаршуулсан байна. | - |
| **ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ:** "Алсын хараа-2050"-ын 5.3.1, Алсын хараа 2050-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.1, 5.3.2, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.1, ЗГҮАХ-ийн 4.1.2, Цахим үндэстэн баримтлах чиглэлийн зорилт 2, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн ... | | | | | | | | |
| **ГУРАВ. 2.5.4.2.цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах** | | | | | | | | |
| 11. | Арга хэмжээ 3.1<br>**Яамны төлөвлөгөөний 50.**<br>Төрийн үйлчилгээг хиймэл оюун ухааны тусламжтайгаар хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий “Ухаалаг E-Mongolia” системийг хөгжүүлнэ. | - | Хөгжүүлж, нэвтрүүлсэн хувилбар | E-Mongolia 4.0 | E-Mongolia 5.0 | - | Нээлттэй тендер зарласан ба`2 оролцогч санал ирүүлсэн нь шаардлага хангаагүй тул дахин зарласан. Ирэх 6 дугаар сарын 17-ны өдөр нээнэ.<br>Тайлант хугацаа болоогүй. | - |
| 12. | Арга хэмжээ 3.2<br>**Яамны төлөвлөгөөний 52.**<br>Блокчейн технологи ашиглан бүртгэлийн үйл ажиллагааг баталгаажуулах ажлыг зохион байгуулна. | 850.0 | Блокчейн технологи нэвтрүүлсэн бүртгэлийн үйлчилгээний тоо | 0 | 1 | - | Блокчейн технологи ашиглан бүртгэлийн үйл ажиллагааг баталгаажуулах ажлын даалгаврыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлуулсан.<br>Түүнчлэн Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 15-ны өдрийн А/96 тушаалаар Блокчейн технологи ашиглан бүртгэлийн үйл ажиллагааг баталгаажуулах ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах зорилго бүхий үнэлгээний хороо байгуулагдсан. Тус тендерт оролцогчдын сонгон шалгаруулах үйл ажиллагаа явагдаж байгаа болно. | |
| **ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ:** "Алсын хараа-2050"-ын 2.2.3, 2.6.4, 5.3.3, 5.3.4, Алсын хараа 2050-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.2.4, 5.3.12, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх5 жилийн үндсэн чиглэлийн 4.2.5, 5.3.3, ЗГҮАХ-ийн 4.1.3, 4.1.5, Цахим үндэстэн баримтлах чиглэлийн зорилт 6, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн | | | | | | | | |
| **ДӨРӨВ. 2.5.4.4.Төрийн байгууллагуудын мэдээллийн сан, мэдээллийн систем, нээлттэй өгөгдлийг уялдуулах, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тогтолцоо, нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, зохион байгуулах, зохицуулах** | | | | | | | | |
| 13. | Арга хэмжээ 4.1<br>**Яамны төлөвлөгөөний 56.**<br>Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн бүртгэл хөтөлнө. | - | Бүртгэсэн мэдээллийн сангийн тоо | 0 | 45 | - | Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн системийг хэрэглээнд нэвтрүүлсний дараа III-IV улиралд бүртгэл хөтлөх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулахаар төлөвлөсөн. | - |
| 14. | Арга хэмжээ 4.2<br>**Яамны төлөвлөгөөний 57.**<br>Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэнэ. | - | Их өгөгдлийн (big data) сан үүсгэх гүйцэтгэлийн хувиар | 0 | 10 | - | Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Ажлын хэсэг (Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын тушаал (2024.11.15, А/51/)-ийн хүрээнд:<br>- Хүний хувийн мэдээлэлд хамаарах 35 төрлийн мэдээлэл, хуулийн этгээдэд хамаарах 14 төрлийн мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох арга, аргачлалын хамт И-Монгол академи УТҮГ-т хүргүүлсэн. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Нийгмийн даатгалын мэдээллийн сан, Нийгмийн халамжийн мэдээллийн сан, Хүн амын өрхийн мэдээллийн сан, Мал тооллогын мэдээллийн сан, Бизнес регистрийн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг тус тус мэдээлэл хариуцагчдаас гаргуулан авах, мета-шинжилгээ хийх ажлыг зохион байгуулсан.<br><br>- Өгөгдлийг 5 төрөл (Hashed keys, Masking, Obfuscataion, Generalization, Perturbation) – өөр тодорхойлох боломжгүй болгон хувиргах хэрэгсэл, хувиргасан өгөгдлийг нууцлалтайгаар ХУР системээр дамжуулах сервисийг тус тус хөгжүүлж дууссан бөгөөд хөдөлмөр, халамж, статистик, даатгалын мэдээллийн сан хариуцсан 3 байгууллагад туршилтаар суурилуулж, заавар гарын авлагаар хангаж ажилласан.<br><br>- "И-Монгол академи" УТҮГ-ын төлөөлөлтэй хамтран Үндэсний статистикийн хороо, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээллийн технологийн төв дээр 2025 оны 05 сарын 27-28-ны өдрүүдэд ажиллаж, өгөгдлийг хувиргах, нууцлан дамжуулах явцад гарсан эх кодын алдааг засварлах, турших ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br><br>- Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нэгтгэх дэд бүтцийг бэлдэх ажлын хүрээнд Үндэсний дата төв дээр 500GB санах ой бүхий нөөцийг үүсгэсэн. | |
| 15. | Арга хэмжээ 4.3<br>Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх платформ хөгжүүлнэ. | - | Нэвтрүүлсэн платформын тоо | 0 | 1 | - | - "Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх платформ хөгжүүлэх" арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах төсвийн тооцоог гаргасан.<br>- "Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх платформ хөгжүүлэх" ажлын даалгаврыг боловсруулсан. | 50 |
| 16. | Арга хэмжээ 4.4<br>**Яамны төлөвлөгөөний 58.**<br>Хүн, хуулийн этгээдийг төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-д холбох ажлыг зохион байгуулна. | - | Шинээр холбогдсон хүн, хуулийн этгээдийн тоо | 0 | 55 | - | 2025 оны эхний хагас жилийн байдлаар төрийн мэдээлэл солилцооны үндсэн “ХУР” системд төрийн 172, хувийн хэвшлийн 462 байгууллага, нийт 634 байгууллага холбогдсон. | 100 |
| 17. | Арга хэмжээ 4.5<br>**Яамны төлөвлөгөөний 59.**<br>Хүн, хуулийн этгээдийг танилт, нэвтрэлтийн систем (ДАН)-д холбох ажлыг зохион байгуулна. | - | Шинээр холбогдсон хүн, хуулийн этгээдийн тоо | 0 | 50 | - | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар Танилт, нэвтрэлтийн нэгдсэн систем (ДАН)-д төрийн 98 байгууллагын 188, хувийн 276 байгууллагын 325 систем бүртгэлтэй 2,220,683 иргэн байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18. | Арга хэмжээ 4.6<br>Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-д холбогдох үйлчилгээ (сервис)-ний тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | - | Шинээр нийлүүлсэн сервисийн тоо | 810 | 820 | - | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 196 дугаар тогтоолоор баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 85 сервис үйлчилгээг шинээр хөгжүүлэн, холбох ажлыг зохион байгуулж, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 855 сервис үйлчилгээ холбогдсон. | 100 |
| 19. | Арга хэмжээ 4.7<br>**Яамны төлөвлөгөөний 60.**<br>Сэлгэн ажиллах /high availability/ дата төвийн тоног төхөөрөмжийн нөөцийг бий болгоно. | 9,557.800 Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | - | Үндэсний дата төв УТҮГ-аас Сэлгэн ажиллах нөөц төвд шаардлагатай сервер, сүлжээ, хадгалах төхөөрөмж зэрэг 10 төрлийн нийт 128 ширхэг техник хэрэгслийн техникийн тодорхойлолтыг боловсруулсан иргүүлсний дагуу “Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх” ЦХИХХЯ/20250102135 дугаар бүхий худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. | 50 |
| 20. | Арга хэмжээ 4.8<br>Үндэсний дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | Ухаалаг Засаг 20,310.00 | Үндэсний дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадал, хувиар | 50 | 100 | - | Үндэсний дата төв УТҮГ-аас дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллийн аюулгүй байдлын 20 төрлийн нийт 102 ширхэг техник хэрэгслийн техникийн тодорхойлолтыг боловсруулсан иргүүлсний дагуу “Ухаалаг засаг 2 төсөл”-ийн хүрээнд “Үндэсний дата төвийн үндсэн болон нөөц төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх" 2.2.1.1 | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугаартай төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, үнэлэх ажил хийгдэж байна. | |
| 21. | Арга хэмжээ 4.9<br>**Яамны төлөвлөгөөний 42.**<br>Камерын хяналтын нэгдсэн систем бий болгоход шаардлагатай тоног төхөөрөмжийн нөхцөл шаардлагыг тодорхойлох суурь судалгаа хийж стандартын төсөл боловсруулах | - | Судалгааны тоо | 0 | - | 1 | Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн "Танилцуулга хүргүүлэх тухай" 7/2857 дугаар албан бичгээр ирүүлсэн Улсын хэмжээнд нэгдсэн дугаарлалтын систем нэвтрүүлэх, нийслэлд Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг өргөтгөх, орон нутагт дуудлага хүлээн авах ажиллагааг Телекамерын хяналтын дэд төвтэй уялдуулан зохион байгуулах ажлын Техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулахад зөвлөх үйлчилгээ авч, системийн шинжилгээ хийлгэхээр танилцуулга ирүүлсэнтэй холбогдуулан холбогдох албан хаагчтай мэдээлэл солилцох зорилго бүхий уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. | - |
| 22. | Арга хэмжээ 4.10<br>**Яамны төлөвлөгөөний 66.**<br>Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн систем хөгжүүлнэ. | 350.0 Урсгал зардал | Нэвтрүүлсэн хувилбар | 1.0 | 2.0 | - | - "Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем хөгжүүлэх" арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах төсвийн тооцоог гаргасан.<br>- Дүгнэлт, зөвлөмжийн системийг суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн бүртгэлтэй нэгтгэн "Төрийн | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн систем хөгжүүлэх” ажлын даалгаврыг боловсруулсан.<br>- “Төрийн мэдээллийн систем, өгөгдлийн сангийн бүртгэл, дүгнэлт зөвлөмжийн систем хөгжүүлэх" ЦХИХХЯ/20250103043 дугаартай тендерийн худалдан авах ажиллагааг Үнэлгээний хороо зохион байгуулж байна. | |
| 23. | Арга хэмжээ 4.11<br>**Яамны төлөвлөгөөний 69.**<br>Авто ослын баримтжуулалтын систем (ослын баримт баталгаажуулалтын платформ) хөгжүүлнэ. | 300.0 Урсгал зардал | Платформын тоо | 0 | 1 | - | Авто ослын баримтжуулалтын систем (ослын баримт баталгаажуулалтын платформ) хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулж 2025.03.31-ний өдөр ТНБД-р батлуулж үйлчилгээ авах тендерийг зохион байгуулах 2025.04.15-ны өдрийн А/95 дугаартай үнэлгээний хорооны тушаалыг батлуулж 2025.04.30-ны тендерийг зарлаж 2025.05.21 өдөр тендерийг нээж үнэлгээ хийгдсэн. Зөвлөмжийг ТНБД-д хүргүүлсэн байна. | 50 |
| 24. | Арга хэмжээ 4.12<br>**Яамны төлөвлөгөөний 44.**<br>Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулна. | 100.0 Урсгал зардал | Боловсруулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | - | - “Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулах” арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах төсвийн тооцоог гаргасан. | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулах" судалгааны ажлын даалгаврыг боловсруулсан. | |
| 25. | Арга хэмжээ 4.13<br>**Яамны төлөвлөгөөний 67.**<br>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслөөр ногоон дата төв байгуулах төслийн санал боловсруулна. | - | Төслийн саналын тоо | 0 | 1 | - | - Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулах" судалгааны ажлын даалгаварт ногоон дата төв байгуулах нөхцөл боломжийн талаар тусгасан бөгөөд судалгааны үр дүнд үндэслэн санал боловсруулахаар төлөвлөсөн. | 50 |
| 26. | Арга хэмжээ 4.14<br>**Яамны төлөвлөгөөний 98.**<br>Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгсэл, хүний нөөцийн тооцоо, судалгаа хийнэ. | 100.0 Урсгал зардал | Судалгааны тоо | 0 | 1 | - | - "Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгслийн тооцоо, судалгаа хийх" арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, шаардагдах төсвийн тооцоог гаргасан.<br>- "Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгслийн тооцоо, судалгаа хийх" ажлын даалгаврыг боловсруулсан.<br>- "Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| . | | | | | | | систем, техник хэрэгсэл, хүний нөөцийн тооцоо судалгаа хийх" ЦХИХХЯ/20250203042 дугаартай үйлчилгээний тендерт шалгарсан Бидсолюшн ХХК-тай гэрээ байгуулах эрх олгох тушаалын төсөл, гэрээний төслийг тус тус боловсруулж, хяналтын шатанд шилжүүлсэн. | |
| 27. | Арга хэмжээ 4.15<br>**Яамны төлөвлөгөөний 70.**<br>Иргэн гар утас, ухаалаг төхөөрөмжөө ашиглан нийгмийн оролцоогоо хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх "Иргэний хяналт" платформ хөгжүүлнэ. | 190.0 Урсгал зардал | Платформ ын тоо | 0 | 1 | - | Ажлын даалгаврыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлуулсан.<br>Түүнчлэн Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/93 тушаалаар Иргэн гар утас, ухаалаг төхөөрөмжөө ашиглан нийгмийн оролцоогоо хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлэх "Иргэний хяналт" платформ хөгжүүлэх ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах зорилго бүхий үнэлгээний хороо байгуулагдсан.<br>Тус тендерт оролцогчдын сонгон шалгаруулах үйл ажиллагаа явагдаж байгаа болно. | 90 |
| **ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ:** "Алсын хараа-2050"-ын 5.3.2, Алсын хараа 2050-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.5, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.2, ЗГҮАХ-ийн 4.1.5, Цахим үндэстэн баримтлах чиглэлийн зорилт 2, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн... | | | | | | | | |
| **ТАВ. 2.5.4.5.Цахим орчинд харилцаа холбоо, мэдээллийн технологийн зөв зохистой хэрэглээний соёлыг нэвтрүүлэх, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэн, тоон хуваагдлыг бууруулах, иргэдийн мэдээлэл авах хүртээмжийг нэмэгдүүлэх** | | | | | | | | |
| 28. | Арга хэмжээ 5.1<br>**Яамны төлөвлөгөөний 72.**<br>Албан бичиг солилцооны дундын системийн хэрэглээг | - | Байгууллаг ын тоо | 0 | 305 | - | Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ажлын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | | | | | | хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн А/22 дугаартай тушаалаар байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг 21 аймагт зохион байгуулж, сургалтын агуулгад албан бичиг солилцооны дундын системийн хэрэглээний талаар тусгасан. Сургалтад төрийн 3,161 албан хаагч хамрагдсан. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2757 байгууллага албан бичиг солилцооны дундын системд холбогдсон байна. | |
| 29. | Арга хэмжээ 5.2 Нээлттэй өгөгдөл, их өгөгдлийн чиглэлээр төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулна. | - | Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 0 | 100 | - | Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх туршилт, нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх платформыг хэрэглээнд нэвтрүүлсний дараа III-IV улиралд сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн. | - |
| **ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ:** "Алсын хараа-2050"-ын 5.3.3, Алсын хараа 2050-ын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.3.2, Шинэ сэргэлтийн бодлогын 6.1.1, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 5.3.3, ЗГҮАХ-ийн 4.1.1, 4.1.3, Цахим үндэстэн баримтлах чиглэлийн зорилт 2.2.1, 2.2.2, 2.3.9, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн | | | | | | | | |
| **ЗУРГАА. “ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | | |
| 30. | Арга хэмжээ 6.1 Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд | - | Боловсруулсан төлөвлөгөө, | Төлөвлөгөө-1 | Тайлан-1 | - | - Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1-р улиралд батлуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнана. | | тайлангийн тоо | | | | - Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 7 хоног, сар, I, II улирлаар тайлагнасан. | |
| 31. | Арга хэмжээ 6.2<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлана. | - | Архивт хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо | Хэрэгжилтээр | Хэрэгжилтээр | | - Тайлант хугацаанд албан бичиг:<br>- Ирсэн бичиг - 150<br>- Явуулсан /шийдвэрлэсэн/ - 115 | 100 |
| 32. | Арга хэмжээ 6.3<br>Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэнэ | - | Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо | Хэрэгжилтээр | Хэрэгжилтээр | - | - Үндсэн болон дэмжих системд холбогдох, сервис үйлчилгээ авах, алдаа тасалдал гарсан талаарх иргэн, хуулийн этгээдийн нийт 25 хүсэлтэд зөвлөгөө, мэдээллийг өгсөн байна. | 100 |
| 33. | Арга хэмжээ 6.4<br>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. | - | ХАСХОМ бөглөх болон хуулийн хэрэгжилтийг хангаж, ажилласан баримтын тоо | Хуульд заасан хугацаанд | Хуульд заасан хугацаанд | - | Албан үүргийн дагуу шийдвэрийн төсөл боловсруулах, төрийн байгууллага болон хүн хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг мөрдөж ажилласан. | 100 |
| 34. | Арга хэмжээ 6.5<br>Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд нь чанартай гүйцэтгэх, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлнэ. | - | Өгсөн үүрэг даалгаврын тоо | Хэрэгжилтээр | Хэрэгжилтээр | - | Шийдвэрийн төсөлд 6 санал, ажлын хэсэг-4, тайлан, мэдээ - 5 тус тус гаргаж холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. | 100 |

## ДОЛОО. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилт 21. "Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх" зорилтын хүрээнд | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 7.1<br><br>Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалтад хамрагдах. | Сертификатын тоо | 2 | 2 | Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалтад 2025 оны 01 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд хамрагдсан. 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдөр шалгалт өгсөн. | 01-12 | 80 |
| 2. | Арга хэмжээ 7.2<br><br>Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн дунд хугацааны сургалтад хамрагдах. | Сертификатын тоо | - | 2 | - | - | - |
| 3. | Арга хэмжээ 7.3<br><br>Эрхэлсэн ажлын чиглэлээр олон улсаас зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцох | Сургалтад хамрагдсан тоо | 5 | 5 | - Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2025 оны 01 сарын 28-ны өдөр зохион байгуулсан "Цахим эрх зүй, түүний хөгжлийн чиг, хандлага" олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцсон.<br>- Гаалийн ерөнхий газраас 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан "Хиймэл оюунд суурилсан дэвшилтэд технологийг нэвтрүүлж, гаалийн шинэчлэлийг бэхжүүлэх төсөл"-ийн уулзалтад оролцсон. | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Чингдао хотноо 2025 оны 04 дүгээр сарын 09-өөс 29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Цахим худалдаа сургалтад хамрагдсан;<br><br>- Бүгд Найрамдах Португал Улсын Гимарайнш хотноо 2025 оны 05 дугаар сарын 26-наас 30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Цахим шилжилтийн асуудлаар чадавхыг бэхжүүлэх" тэтгэлэгт хөтөлбөрийн хоёр дахь шатны сургалтад хамрагдсан. | | 100 |
| 4. | Арга хэмжээ 7.4<br>Дотоодод зохион байгуулагдах сургалт, хурал, семинарт оролцох | Сургалтад хамрагдсан тоо | 5 | 5 | - "Мэдээллийн технологи, хиймэл оюун ухааны хөгжлийн чиг хандлага" сэдэвт сургалтад 2025 оны 01 дүгээр 06-ний өдөр хамрагдсан<br>- "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулсан мод тарих үйл ажиллагаанд 2024 оны 05 дугаар 21-ний өдөр оролцсон.<br>- Галлериа Улаанбаатарт 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Кибер аюулгүй байдлын нөхцөл байдлын үнэлгээний тайлангийн хуралд хамрагдсан;<br>- Төрийн ордонд 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулагдсан Их өгөгдөл, | 01-12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хиймэл оюуны үндэсний стратегийн анхдугаар хэлэлцүүлэгт хамрагдсан. | | |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* ***Төсвийн шууд захирагч***

Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч ......................... /П.Алтан-Од/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

............................

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:* ***Нэгжийн дарга***

Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын
газрын дарга ......................... Б.Бат-Өлзий
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

...............................

*Тайлагнасан:* ***Нэгжийн дарга***

Төрийн үйлчилгээний дахин загварчлалын
хэлтсийн дарга ......................... /Д.Батбаяр/
*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)*

...............................